

Хууль зүйн сайдын 2014 оны
A/125 дугаар тушаалын хавсралт

**ХУУЛЬ ТОГТООМЖИЙН СИСТЕМЧЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ, ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ,
СУРТАЛЧИЛГАА, ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТАЛААРХ МЭДЭЭ**

2025 оны 03 сарын 25-ны өдөр

“Баян-Өндөр”

Д/д	Ажлын чиглэл	Үзүүлэлт	Баян Өндөр сүм	Бүгд
1	Хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл	Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санд байгаа эрх зүйн актын тоо	527	
		Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санг шинээр баяжуулсан эрх зүйн актын тоо	2	
		Системчлэл хийсэн хууль тогтоомж	1999-2025 оны Төрийн мэдээлэл, Хууль зүйн мэдээлэл сэтгүүл	
		Өөрчлөлт хөдөлгөөн хийсэн зүйл заалтын тоо	5	
	Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системээс лавлагаа мэдээлэл өгсөн	Иргэд	55	
		Байгууллага	5	
	Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн гар сангаас лавлагаа мэдээлэл өгсөн	Иргэд	20	
		Байгууллага	4	
2	Аймаг, Сумын Засаг даргын захирамжийн хууль зүйн үндэслэлийг хянах	Хянаж санал өгсөн аймаг, сумын Засаг даргын захирамж	2009-2024 оны 12 сар хүртэлх Сумын Засаг даргын захирамж, ЗДТГ-ын даргын тушаал	
	Үүнээс захиргааны хэм хэмжээ тогтоосон	Хууль зүйн яаманд хянуулж бүртгүүлсэн	1 2025.01.24 Дугаар 7099	

			Хууль зүйн яамнаас дүгнэлт гаргаж буцаасан	-	
3	Эрх зүйн сургалт, сурталчилгаа	Зохион байгуулсан эрх зүйн сургалт, хэлэлцүүлэг	3		
		Үүнээс сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан хүний тоо	85		
		Зохион байгуулсан эрх зүйн сурталчилгаа	5		
		Боловсруулсан гарын авлага, сургалт, сурталчилгааны материал	0		
		Радио, телевизийн нэвтрүүлэг	0		
		Сонин хэвлэлээр сурталчилсан	“Бумбатын мэдээ” сонingoор 0 удаа		
		Бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан	Сумын албан ёсны фэйсбүүк группээр, эрх зүйн хөтөчийн цахим хуудсаар тогтмол явуулж хэвшсэн.		

МЭДЭЭ ГАРГАСАН:


ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

Ш.ЦЭРЭНСУГАР

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Д.СОНИНБАЯР



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМАНД ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ,
СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР 2025 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН
БАЙДЛААР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2025.03.25.

"Бумбат"

Эрх зүйн сургалт, сурталчилгааны сумын нэгдсэн төлөвлөгөөг сумын Засаг даргын А/28 дугаар захирамжийн хавсралтаар батлуулж, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Төсөвт байгууллагын дарга эрхлэгч нар, төрийн албан хаагчдад цахимаар болон танхимаар санал авч 2025 оны хууль, эрх зүйн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Монгол Улсын Үндсэн хууль, Хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлэг /ХАСХОМ/ гаргах, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг үнэлэх тухай сургалт, багийн нийтийн хурлын дэг тогтоох тухай сургалт мэдээллийг ИТХурлын мэргэжилтэн ИТХ-ын төлөөлөгч нарт, иргэдэд эрх зүйн мэдлэг олгож ажилласан. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн тухай сургалтыг ЗДТГ-ын албан хаагчид, төлөөлөгч нарт, Төрийн албан хаагчийг ёс зүйн тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар сургалтыг албан хаагчдад өгч мэдлэг олгож ажилласан. Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 214 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын архив, бичиг хэргийн ажилтан сурталчлан ажиллаж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 13 дугаар зарлигийн хавсралтаар батлагдсан "Эхийн алдар одонгоор шагнах журам"-ыг иргэдэд сурталчлан ажиллаж байна. Бодлогын баримт бичиг хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам, ЗГХЭГ-ын 2023 оны 98 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний нэмэлт өөрчлөлт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангуулах ярилцлагын тэмдэглэл, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт бичих загвар аргачлалыг албан хаагчдад танилцуулж арга зүйн зөвлөгөө өгч албан хаагчдын хувийн хэргийг шинэчлэн ажилласан. Албан хаагчид төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулсан. Шинээр томилогдсон албан хаагчдад байгууллагын дотоод журам, төрийн албаны тухай хууль, төрийн болон албаны нууцын тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуультай танилцуулж, хөдөлмөрийн гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал зааж арга зүйн зөвлөгөө өгч гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд нээлттэй мэдээллэхээр заасан мэдээлэл, үйлчилгээг байгууллагын цахим хуудсаар болон мэдээллийн самбараар дамжуулан албан хаагчдын хийж хэрэгжүүлсэн ажил, үзүүлж буй

үйлчилгээ мэдээллийг тогтмол иргэдэд ил тод мэдээллэн ажиллаж байна. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд ГХУССЗөвлөлтэй хамтарч Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Замын хөдөлгөөний дүрмийн хууль тогтоомж, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн тухай сургалтыг ААНБ, багуудаар сургалт хийх төлөвлөгөө гарган боловсруулан батлуулав. Байгаль хяналтын Улсын байцаагч дэлхийн усны өдөртөө холбогдуулан Усаа хайрлан хамгаалахын ач холбогдлын талаар сурталчлан ажилласан. Аймгийн ИТХурлын ажлын хэсэг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар сумын ИТХурлын төлөөлөгч нарт сургалт хийсэн. Төрийн албаны зөвлөлийн шалгалтын ажлын хэсэг Төрийн албаны тухай хуулиар нийт төрийн албан хаагчдад сургалт мэдээлэл өгсөн.

-Эрх зүйн хөтөчийн цахим хуудсаар шинээр батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийн мэдээ мэдээллийг төрийн албан хаагчид, иргэдэд цахимаар сурталчилан ажиллаж байна. Эрх зүйн үндэсний хөтөч www.e-khutuch.mn, legalinfo.mn, d.parliament.mn сайтыг иргэдэд сурталчлан ажилласан. Шаардлагатай хууль тогтоомж эрх зүйн актыг хяналтандаа авч Малчны тухай хууль, Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, Хүүхэд хамгааллын тухай хууль, Боловсролын ерөнхий хуулиар хувийн хэрэг нээж эзэнжүүлсэн. Нийгмийн даатгалын багц хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Малчны тухай хууль, Төрийн албан хаагчдын цалин хөлстэй холбоотой шинээр батлагдсан тогтоолуудыг цахимаар сурталчлан ажиллаж байна.

ТАЙЛАН БИЧСЭН:
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН
ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА



Д.СОНИНБАЯР